

ОГНОО: 2024/08/05

№:

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ

РАГНАРОК ИНВЕСТМЕНТ ХХК

(Компани)

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ, ТАЙШИР СУМЫН ЗАСАГ
ДАРГА

(Нутгийн захиргааны байгууллага)

ДЭЛГЭРЭНГҮЙ

ТАЛУУД:

Нэр	Рагнарок Инвестмент ХХК
Регистрийн дугаар	6717128
Товчилсон нэр	Компани
Холбоо барих:	Хаяг: СБД, 1-р хороо, Меру оффис, 305 тоот Утас: 77774114

Нэр	Говь-Алтай аймаг, Тайшир сумын Засаг дарга
Товчилсон нэр	Нутгийн захиргааны байгууллага
Холбоо барих	Хаяг: Говь-Алтай аймаг, Тайшир сум, ЗДТГ Утас: 80111917

ҮНДЭСЛЭЛ

Энэхүү Нийгмийн хариуцлагын гэрээ /цаашид “Гэрээ” гэх/-г талууд Монгол Улсын Иргэний хууль, Ашигт малтмалын тухай хууль, Төсвийн тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн доор дурдсан нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

ТОХИРОЛЦСОН НӨХЦЛҮҮД

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү гэрээний зорилго нь Говь-Алтай аймгийн Тайшир суманд үйл ажиллагаа явуулж буй Компаниас орон нутгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах, байгаль орчин, хүнд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллийг бууруулах, иргэдээс ирүүлсэн санал санаачилгыг дэмжин ажиллахад дэмжлэг үзүүлэх нийгмийн хариуцлагыг тодорхойлох, нутгийн захиргааны байгууллагаас хууль тогтоомжийн хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигчид үйл ажиллагаагаа хэвийн явуулахад дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү гэрээг хэрэгжүүлэхдээ Талууд хууль дээдлэх, харилцан хүндэтгэх, ил тод байх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, сайн дурын үндсэн дээр гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлэх зарчмуудыг баримтална.

Хоёр. Нийгмийн хариуцлага

- 2.1. Компаниас нийгмийн хариуцлагын хүрээнд нутгийн захиргааны байгууллагын хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг дэмжих, санхүүжүүлэх зорилгоор ерэн таван сая төгрөгийн хандивыг тодорхой үе шаттайгаар хэсэгчлэн Гэрээний хугацаанд нутгийн захиргааны байгууллагын хөгжлийн сангийн тоот дансанд шилжүүлнэ.
- 2.2. Нутгийн захиргааны байгууллага нь хууль тогтоомжид заасан бүрэн эрх, чиг үүргийн хүрээнд Гэрээний 2.1-т заасан хандивыг дараах ажил, арга хэмжээнд захиран зарцуулна. Үүнд:
 - 2.2.1. Нутаг орны өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, хүүхэд залуучуудын мэдлэгийг дээшлүүлэх, оюутны сургалтын тэтгэлэг олгох;
 - 2.2.2. Байгаль орчин, хүнд амд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, байгаль орчныг хамгаалах, мод тарих, үржүүлэх төсөл;
 - 2.2.3. Иргэн, төрийн бус байгууллагаас санаачилсан орон нутгийн хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх;
 - 2.2.4. Иргэдийн амьдрах орчныг сайжруулах, хүүхэд залуучуудын цагийг зөв боловсон өнгөрүүлэх төв барих;
 - 2.2.5. Цаг агаарын хүнд нөхцөлд орон нутгийн малчдад туслалцаа үзүүлэх, гамшиг, аюулт үзэгдлээс ард иргэдийн урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах чадавхыг нэмэгдүүлэх, гамшигийн дараах нөхөн сэргээлт.
 - 2.2.6. Спортын арга хэмжээ
- 2.3. Гэрээний 2.1-т заасан хандивыг дараах зүйлд захиран зарцуулахыг хориглоно. Үүнд:
 - 2.3.1. Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад ажил, арга хэмжээ;

- 2.3.2. Улс төрийн намын үйл ажиллагааг санхүүжүүлэх;
- 2.3.3. Нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа;
- 2.3.4. Зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, хохирол нөхөн төлөх;
- 2.3.5. Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсөв, төлөвлөгөөнд тусгаж батлаагүй ажил, төсөл хөтөлбөр.

Гурав. Нутгийн захиргааны байгууллагын эрх, үүрэг

- 3.1. Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд Компанийг ашигт малтмал эрэх, хайх үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөлөөр хангана.
- 3.2. Хандивыг зөвхөн Гэрээний 2.2-т заасан зориулалтын дагуу ашиглах бөгөөд ажил, арга хэмжээний талаарх мэдээллээр Компанийг тогтмол хангана.
- 3.3. Гэрээний 2.2-т заасан ажил, арга хэмжээний хандивын зарцуулалтад хяналт тавьж, хандивыг зөв зохистой зарцуулна.
- 3.4. Нутгийн захиргааны байгууллага нь гэрээний хугацаанд Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн аливаа үйл ажиллагааг орон нутгийн иргэдэд тухай бүрт нь үнэн зөв мэдээлж байна.
- 3.5. Компанийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг хуулийн хугацаанд өгнө.
- 3.6. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал гаргах эрхтэй байна.
- 3.7. Нийтийн албандаа нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасан хуулиар хориглосон хүсэлт гаргах, компанийн сайн дурын үндсэн дээр гүйцэтгэх үйл ажиллагааг заавал гүйцэтгүүлэхээр тулган шаардахыг хориглоно.

Дөрөв. Компанийн эрх, үүрэг

- 4.1. Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэн ажиллана.
- 4.2. Байгалийн баялгийг зохистой ашиглаж, байгаль орчны нөхөн сэргээлтийг тухайн бүс нутагт нь тохируулан мэргэжлийн түвшинд, технологийн дагуу, стандартын шаардлага хангахуйц хийж гүйцэтгэнэ.
- 4.3. Компани үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж шийдвэрлүүлнэ.
- 4.4. Нутгийн захиргааны байгууллагаас Гэрээний 2.2-т заасан ажил, арга хэмжээний хэрэгжилт, хандивын зарцуулалтын тухай мэдээлэл авах, санал гаргах эрхтэй байна.
- 4.5. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал гаргах эрхтэй байна.

- 4.6. Нутгийн захиргааны байгууллагаас хандивыг Гэрээний 2.2-т заасан ажил, арга хэмжээнд захиран зарцуулахыг шаардах, Гэрээний 2.3-т заасан үйл ажиллагаанд захиран зарцуулсан тохиолдолд хандивыг буцаан шаардах эрхтэй байна.

Тав. Гэрээний биелэлтэд хяналт тавих, дүгнэх

- 5.1. Талууд гэрээний биелэлтэд тавих хяналтыг хамтран хэрэгжүүлнэ.
- 5.2. Нутгийн захиргааны байгууллагаас Гэрээний 2.2-т заасан ажил, арга хэмжээг хандиваар санхүүжүүлсэн тухай бүр Компанид мэдэгдэж, хандивын зарцуулалтыг ажил, арга хэмжээ дуусгавар болсноос хойш ажлын 5 өдрийн дотор Компанид хүргүүлнэ.
- 5.3. Нутгийн захиргааны байгууллага хандивыг захиран зарцуулж дуусгавар болсон тохиолдолд Талууд харилцан гэрээний хэрэгжилт, хандивын зарцуулалтыг дүгнэж баталгаажуулна.

Зургаа. Гэрээний хариуцлага

- 6.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Эрүүгийн хууль, болон холбогдох хууль тогтоомжийн дагуу буруутай этгээдэд хариуцлага хүлээнэ.
- 6.2. Компани нь энэхүү гэрээний дагуу Нутгийн захиргааны байгууллагын нээсэн тусгай дансанд холбогдох төлбөрийг шилжүүлсэнээр нийгмийн хариуцлагын хүрээнд хүлээсэн үүргээ биелүүлсэнд тооцно.
- 6.3. Энэхүү гэрээгээр Компани хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг, хариуцлагаас чөлөөлөгдөх, эсхүл бусдаас давуу эрхтэйгээр үйл ажиллагаа явуулах үндэслэл болохгүй.
- 6.4. Компани Нутгийн захиргааны байгууллагаас хандивыг Гэрээний 2.2-т заасан ажил, арга хэмжээнд захиран зарцуулахыг шаардах, Гэрээний 2.3-т заасан үйл ажиллагаанд захиран зарцуулсан тохиолдолд Компани эрх бүхий байгууллагад мэдэгдэх бөгөөд хандивыг нутгийн захиргааны байгууллагаас буцаан шаардана.

Долоо. Маргаан шийдвэрлэх

- 7.1. Гэрээг тайлбарлах болон хэрэгжүүлэхтэй холбоотой ямар нэг маргаан гарвал талууд эхний шатанд эв зүйгээр шийдвэрлэх бүхий л арга хэмжээг авна.
- 7.2. Гэрээний 7.1-т зааснаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын хуулийн дагуу Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

Найм. Мэдэгдэл, баталгаа

- 8.1. Нутгийн захиргааны байгууллага дараах мэдэгдэл, баталгааг Компанийн өмнө гаргаж байна. Үүнд:

- 8.1.1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан хандив авахтай холбогдсон хязгаарлалтыг хангаж байгаа болно.
- 8.1.2. Төсвийн тухай хуульд заасны дагуу хандивыг хүлээн авч, бүртгэж, захиран зарцуулна.
- 8.2. Компани нь дараах мэдэгдэл, баталгааг Нутгийн захиргааны байгууллагын өмнө гаргаж байна. Үүнд:
- 8.2.1. Компанийн хувьд, холбогдох хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан, хууль ёсны тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхэлдэг.
- 8.2.2. Компанийн хувьд энэхүү гэрээнд гарын үсэг зурсан этгээд нь эрх бүхий этгээд болно.
- 8.2.3. Хандив нь Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт заасан хандив бөгөөд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчөөгүй болно.
- 8.3. Гэрээний 8.1 болон 8.2-т заасан мэдэгдэл, баталгааны үнэн зөвийг мэдэгдэл, баталгаа гаргагч тал хариуцах бөгөөд нөгөө тал нь хариуцлага хүлээхгүй болно.

Ec. Бусад

- 9.1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох ба гэрээ нь байгуулагдснаас хойш 5 /таван/ жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 9.2. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд талууд харилцан тохиролцож зөвхөн бичгээр оруулах бөгөөд 2 хувь үйлдэн, гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулна. Гэрээний нэмэлт, өөрчлөлтийг гэрээнд хавсаргах ба энэ нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.
- 9.3. Гэрээг Монгол хэл дээр 2 эх хувь үйлдэнэ. Эх хувь бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

Гэрээ байгуулсан:


**НУТГИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ:**

*Говь-Алтай аймгийн Тайшир сумын Засаг
дарга: М.Болдбаатар*

Хаяг: Говь-Алтай аймаг, Тайшир сум, ЗДТГ

Утас: 80111917

Гарын үсэг:



**РАГНАРОК ИНВЕСТМЕНТ ХХК-Г
ТӨЛӨӨЛЖ:**

Гүйцэтгэх захирал: З.Ган-Очир

Хаяг: СБД, 1-р хороо, Меру оффис, 305 тоот

Утас: 99110973

Гарын үсэг:



Талуудын хооронд 2024/03/05.....өдөр байгуулагдсан
“Нийгмийн хариуцлагын гэрээ”-ний Хавсралт №1

Огноо:

Гэрээний дугаар:

Нийгмийн хариуцлагын гэрээний хүрээнд олгох санхүүжилтын хуваарь

Чиглэл тус бүрээр	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжүүлэх хугацаа	Төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг өгөх хандивын хэмжээ /төгрөгөөр/
Байгаль орчныг хамгаалах чиглэлээр	<i>2024 оны тоосоо, агаа хамгаалсан, урсац шийн зарцуулалт хүчинэж болна</i>	2024	15 000 000
Дэд бүтцийг хөгжүүлэх, сайжруулах чиглэлээр	<i>2024-03-05</i>	2025	15 000 000
		2026	15 000 000
Орон нутгийн хөгжлийг дэмжих, иргэдийн амьдрах орчныг сайжруулах, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр		2027	25 000 000
		2028	25 000 000

Баталсан:

**НУТГИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ:**

Говь-Алтай аймгийн Тайшир сумын
Засаг дарга: М.Болдбаатар

Хаяг: Говь-Алтай аймаг, Тайшир сум

Утас: 80111917

Гарын үсэг:



**РАГНАРОК ИНВЕСТМЕНТ ХХК-Г
ТӨЛӨӨЛЖ:**

Гүйцэтгэх захирал: З.Ган-Очир

Хаяг: СБД, 1-р хороо, Меру оффис, 305 тоот

Утас: 99110973

Гарын үсэг:

